

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын ... өдөр

Дугаар

Улаанбаатар хот

“Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д нэмэлт оруулах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, үнэлгээний тайланг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалаар батлагдсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-ын “Хөдөлмөрийн хүнд нөхцөл”-ийн 3 дахь хэсэгт “галт тэрэгний дарга”, “галт тэрэгний мастер-засварчин” гэж нэмсүгэй.

2. Энэхүү тушаалыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, холбогдох хуулийн заалтад дурьдсан болзолыг хангаж байгаа тохиолдолд тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоохыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т зөвшөөрсүгэй.

САЙД

С.ЧИНЗОРИГ